



Зажиргжсаны хэмээн комиссийн
затын улсын нэгдсэн санд
2020 оны 02 сарын 06-ны
сардийн 4695 дугаарт бүртгэв.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот


Г

Г

“Телевизийн өргөн нэвтрүүлгийн станцад ашиглах
радио давтамжийн зурvasын хуваарилалт, техникийн шаардлага,
норматив”-ыг батлах тухай

Радио долгионы тухай хуулийн 5¹.1.2 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Телевизийн өргөн нэвтрүүлгийн станцад ашиглах радио давтамжийн зурvasын хуваарилалт, техникийн шаардлага, норматив”-ыг энэхүү тогтоолын хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тус хорооны 2013 оны 28 тоот, 2017 оны 42 тоот тогтоол, 2018 оны 33 тоот тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА 
Г.ЧИНЗОРИГ

ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА 
Т.НАРАНМАНДАХ



Харилцаа холбооны зохицуулах хорооны
2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн

42 тоот тогтоомын
хавсралт

**ТЕЛЕВИЗИЙН ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН СТАНЦАД АШИГЛАХ
РАДИО ДАВТАМЖИЙН ЗУРВАСЫН ХУВААРИЛАЛТ,
ТЕХНИКИЙН ШААРДЛАГА, НОРМАТИВ**

НЭГ.ЗОРИЛГО

1.1. Энэхүү баримт бичиг нь Дэлхийн радиогийн их хурлаас баталсан Олон улсын радио давтамжийн дүрэм болон Монгол улсын “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”-ийн заалтуудыг үндэслэн телевизийн өргөн нэвтрүүлгийн (ТӨН) станцад ашиглах радио давтамжийн зурvasыг хуваарилах, радио давтамжийг үр дүнтэй ашиглах техникийн шаардлага, нормативыг тодорхойлоход оршино.

**ХОЁР.РАДИО ДАВТАМЖИЙН ЗУРВАСЫГ ХУВААРИЛАХ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

2.1 Зурvasын хуваарилалтад харилцаа холбооны дэвшилтэт технологийг хөгжүүлэх, тусгай зөвшөөрлийн нөхцөл болон сүлжээний үйл ажиллагааны шаардлагыг тогтоох зорилгоор Радио долгионы тухай Монгол Улсын хуулийн 3.1.4¹ дэх заалт “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”-ийн (цаашид “давтамжийн зурvasын төлөвлөлт” гэх) заалтуудыг үндэслэл болгоно.

2.2 Зурvasын хуваарилалтад ашиглах техникийн шаардлага, нормативд Олон улсын цахилгаан холбооны байгууллагын ITU-R BT.2036-1 зөвлөмжинд тодорхойлсон доорхи нөхцлүүдийг тусган авч үзнэ. Үүнд:

2.2.1 “Суурин хүлээн авалт буюу RM1 хүлээн авалт” гэж барилгын дээвэрт суурилагдсан чиглэлтэй хүлээн авах антен ашиглан хүлээн авахаар тодорхойлогдох ба оронгийн хүчлэгийн тооцоог хүлээн авах газрын гадаргуйгаас дээш 10 метрийн өндөрт хийнэ.

2.2.2 “Зөөврийн төхөөрөмжийн хүлээн авалт буюу RM2 хүлээн авалт” нь доорх нөхцлөөр тодорхойлогдоно. Үүнд:

- RM2A тасалгааны хүлээн авалт (гаднах)-Зөөврийн хүлээн авагч нь газрын гадаргуйгаас 1.5 метрээс хэтрэхгүй өндөрт байрласан өөрт суурилагдсан эсвэл түүнд холбогдсон антсигтай хүлээн авалт;
- RM2B хөдөлгөөнт хүлээн авалт - дохиог хөдөлгөөн дунд хүлээн авснаар тодорхойлогдох ба шалны эсвэл газрын гадаргуйгаас дээш 1.5 метрээс хэтрэхгүй өндөрт байрласан зөөврийн төхөөрөмж эсвэл автомашины хүлээн авагч.

2.2.3 Зөөврийн төхөөрөмжөөр хүлээн авах байршил нь хоёр эсхүл түүнээс дээш давхарт байрлаж байвал зөөврийн төхөөрөмж, дохионы түвшинд засвар оруулна.

¹ 3.1.4 “үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт” гэж радио давтамжийн нийт зурvasыг радио холбооны үйлчилгээний төрөлд хуваасан хуваарилалтыг;



- 2.2.4 “Зөөврийн төхөөрөмжийн тасалгааны доторх буюу RM3 хүлээн авалт” гэж зөөврийн хүлээн авагч нь тасалгаанд шалнаас 1.5 метрээс хэтрэхгүй өндөрт байрласан, өөрт суурилагдсан антентай хүлээн авалт;
- 2.3 Радио давтамжийн 470-702 МГц-ийн зурvasын ашиглалтыг хилийн бүсэд Олон улсын Радио давтамжийн дурэм болон хил орчмын радио давтамжийн зохицуулалтын гэрээг мөрдөнө.
- 2.4 Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд тодорхойлогдсон ТӨН-ийн станцад ашиглах нийт радио давтамжийн зурvasыг доорхи хуваарилалтын дагуу радио суваг үүсгэн ашиглана. Үүнд:
- 2.4.1 Радио давтамжийн 470-702 МГц-ийн зурvasын хуваарилалт, нийтлэг техникийн шаардлагыг хавсралт 1;
- 2.4.2 Улаанбаатар хотын бүсэд төрийн телевизийн сүлжээгээр дамжуулах станцуудад ашиглах радио давтамжийн 470-534 МГц-ийн зурvasын хуваарилалтыг хавсралт 2;
- 2.4.3 Улсын хэмжээнд Улаанбатар хотын бүсээс бусад байршилд телевизийн дамжуулах станцуудад ашиглах радио давтамжийн 470-566 МГц-ийн зурvasын хуваарилалтыг хавсралт 3;
- 2.4.4 Телевизийн өргөн нэвтрүүлэгт ашиглах радио релейний станцын радио давтамжийн зурvasын хуваарилалт, техникийн шаардлагыг хавсралт 4.
- ГУРАВ. ТЕЛЕВИЗИЙН ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН СТАНЦАД
ДАВТАМЖИЙН СУВАГ ХУВААРИЛАХАД БАРИМТЛАХ
БАРИМТ БИЧИГ**
- 3.1 Телевизийн өргөн нэвтрүүлгийн 470-702 МГц-ийн давтамжийн зурваст зөөгч давтамжийн суваг хуваарилахад доорхи баримт бичгүүдийг мөрдлөг болгосон. Үүнд:
- 3.2.1 Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 275 тоот тогтоолоор батлагдсан “Радио телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх үндэсний хөтөлбөр”;
- 3.2.2 Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын даргын 2016 оны А59 тоот тушаалаар баталсан “Үндэсний радио давтамжийн зурvasын хуваарилалтын хүснэгт”;
- 3.2.3 Олон улсын цахилгаан холбооны байгууллагын ITU-R BT.2036-1 “Тоон газрын сүлжээний телевизийн системүүдийн давтамжийн төлөвлөлтөнд ашиглах хүлээн авах төхөөрөмжүүдийн характеристик” зөвлөмж;
- 3.2.4 Харилцаа холбооны зохицуулах хорооны 2006 оны 48-р дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хэмжээнд тоон телевизийн газрын сүлжээнд олон улсын тоон телевизийн DVB-T, DVB-T2 стандартыг сонгох тухай”;
- 3.2.5 Олон улсын цахилгаан холбооны байгууллагын 2006 оны Женевийн хурлаар хэлэлцсэн “1 ба 3 бүсийн орнуудад 174-230 МГц болон 470-862 МГц давтамжийн зурваст газрын сүлжээний өргөн нэвтрүүлгийн төлөвлөлт”;
- 3.2.6 MNS 5397:2004 “Олон сувгийг олон цэгт түгээх системийн техникийн шаардлага” стандарт.



3.2.7 MNS 6400:2013 “Газрын тоон өргөн нэвтрүүлгийн DVB-T2 системийн нэвтрүүлэх төхөөрөмжид тавих техникийн шаардлага” стандарт.

3.2.8 MNS 6401:2013 Тоон телевиз. Газрын тоон өргөн нэвтрүүлгийн DVB-T2 системийн хүлээн авах төхөөрөмжид тавих техникийн шаардлага

3.2.9 MNS 6472:2014 Тоон дүрсийн өргөн нэвтрүүлэг. Тоон телевизийн DVB-T2 тюнертэй хэрэглэгчийн хүлээн авах төхөөрөмжийн үзүүлэлт, хэмжилт ба шалгалтын аргачлал

ДӨРӨВ. ХЯНАЛТ БА БУСАД

4.1 Өргөн нэвтрүүлэгт ашиглах нэвтрүүлэх болон хэрэглэгчийн төхөөрөмж нь Олон улсын баталгаажилтын байгууллагын тохирлын гэрчилгээтэй эсвэл MNS6400:2013, MNS6401:2013, MNS6472:2014 стандартын хангасан болохыг Зохицуулах хороонд хянуулж, тохирлын тэмдэг, тохирлын гэрчилгээг авсан байна.

4.2 Өргөн нэвтрүүлэгт ашиглах радио релейний станц нь Зохицуулах хорооноос баталсан баталгаажуулалт болон техникийн нөхцөл шаардлагыг мөрдөж ажиллах ба Зохицуулах хорооноос хүлээн зөвшөөрсөн Олон улсын баталгаажилтын байгууллагын тохирлын гэрчилгээтэй болохыг Зохицуулах хороонд хянуулна..

4.3 Энэхүү хуваарилалт, техникийн шаардлага, нармативын хэрэгжилтэд Зохицуулах хороо болон харилцаа холбооны хяналтын улсын байцаагч холбогдох хууль тогтоомын дагуу хяналт тавьж ажиллана.

4.4 Дэлхийн радио холбооны их хурлын шийдвэр, зөвлөмж, техник технологийн хөгжил, олон улсын болон үндэсний стандарт, РД-ийн төлөвлөлт, нөөц, дахин хуваарилалтаас хамааруулан тухай бүр нэмэлт, өөрчлөлт орж болно.

-----oo-----



“Телевизийн өргөн нэвтрүүлгийн станцад ашиглах
радио давтамжийн зурvasын хуваарилалт, техникийн
нөхцөл, шаардлага”-ын
Нэгдүгээр хавсралт

РАДИО ДАВТАМЖИЙН 470-702 МГЦ-ИЙН ЗУРВАСЫН ХУВААРИЛАЛТ, НИЙТЛЭГ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

Нэг. Радио давтамжийн зурvasын хуваарилалт, суваг үүсгэх

1.1 Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд /цаашид төлөвлөлт гэх/ тусгагдсан 470-702 МГц-ийн давтамжийн зурvasыг ашиглах хуваарилалт, ашиглалтыг хүснэгт 1-д тодорхойлсон.

Хүснэгт 1. 470-702 МГц давтамжийн зурvasын хуваарилалт

ОУЦХБ-ын хуваарилалт I бүс	Үндэсний хуваарилалт	Ашиглалт
470-702 ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ 5.149 5.291A 5.294.296 5.300 5.304 5.306 5.311A 5.312	470-702 ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ	470-702 МГц-ийн давтамжийн зурvasыг ТООН ТЕЛЕВИЗИЙН ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГТ (DVB-T2) ашиглана.

1.2 ТӨН-ийн газрын сүлжээнд ашиглах 470-702 МГц-ийн давтамжийн зурvasыг хүснэгт 2-т үзүүлсний дагуу суваг үүсгэнэ.

Хүснэгт 2. Телевизийн IV ба V царааны зөөгчийн дугаар, давтамжийн зурvas, зөөгч давтамж

Ультра хэт богино долгион (UHF)					
Цараа IV			Цараа V		
Зөөгчийн дугаар	Давтамжийн зурvas, МГц	Төвийн давтамж, МГц	Зөөгчийн дугаар	Давтамжийн зурvas, МГц	Төвийн давтамж, МГц
21	470-478	474	35	582-590	586
22	478-486	482	36	590-598	594
23	486-494	490	37	598-606	602
24	494-502	498	38	606-614	610
25	502-510	506	39	614-622	618
26	510-518	514	40	622-630	626
27	518-526	522	41	630-638	634
28	526-534	530	42	638-646	642
29	534-542	538	43	646-654	650
30	542-550	546	44	654-662	658
31	550-558	554	45	662-670	666
32	558-566	562	46	670-678	674
33	566-574	570	47	678-686	682
34	574-582	578	48	686-702	690



Хоёр. Сувгийн хуваарилалтын шаардлага, норматив

2.1 ТӨН-ийг дамжуулах давтамжийн зурваст мөрдөх хүлээн авалтын суурин, хөдөлгөөнт, зөөврийн төхөөрөмжийн гаднах болон доторхи хүлээн авалтанд харьцуулах оронгийн хүчлэгийн хамгийн бага түвшинг (E_{min}^{ref}) хүснэгт 3-д үзүүллээ.

Хүснэгт 3. IV/V царааны DVB-T2 хүлээн авагчийн харьцуулах үзүүлэлтүүд

Хүлээн авалтын горим	RM1	RM2a	RM2b	RM3
Давтамж f_r (МГц)	650	650	650	650
Эквивалент шуугианы зурвасын өргөн (МГц)	7.77	7.77	7.77	7.77
Хүлээн авагчийн шуугианы зураглал (dB)	6	6	6	6
Хүлээн авах шуугианы оролтын чадал (дБВт)	-129	-129	-129	-129
RF зөөгчийн дохио/шуугианы харьцаа C/N (dB)	20	18	18	18
Хүлээн авах хамгийн бага оролтын чадал (дБВт)	-109	-111	-111	-111
Хүлээн авах оролтын хамгийн бага хүчдэл, 75Ω (дБ(мкВ))	29.7	27.7	27.75	27.75
$f_r = 650$ МГц үеийн харьцуулах хамгийн бага оронгийн хүчлэг (E_{min}^{ref}) (дБ(мкВ/м))	45.5	50.5	50.5	50.5

2.2 ТӨН-ийг дамжуулах бусад давтамжийн зурваст мөрдөх хүлээн авалтын суурин, хөдөлгөөнт, зөөврийн төхөөрөмжийн гаднах болон доторхи хүлээн авалтын харьцуулах хамгийн бага оронгийн хүчлэгийн нэмэлт засварлах фактор ашиглах ба доорх томъёололыг хэрэглнэ:

$$(E_{min})_{ref}(f) = (E_{min})_{ref}(f_r) + 20 \log_{10} (f/f_r)$$

Энд: f ашиглах давтамж ба f_r хүснэгтэд иш татсан харьцуулах давтамж

2.3 ТӨН-ийн дамжуулалтын онцлог, давтамжийн ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх зорилгоор нийт радио давтамжийн зурвасыг хүснэгт 4-т заасан хуваарилалтаар ашиглана.

Хүснэгт 4. Телевизийн IV ба V царааны сувгийн ашиглалт, стандарт

Бүс нутгийн ангилаал	Ашиглах давтамж зурvas, стандарт			
	Үндэсний болон орон нутгийн ТӨН-т ашиглах		Олон сувгийг олон цэгт түгээх системд ашиглах	
Улаанбаатар	470-534 МГц	DVB-T2	534-702 МГц	DVB-T2
Дархан, Эрдэнэт хотууд болон 10 000 дээш хүн амтай сум, суурин	470-566 МГц	DVB-T2	566-702 МГц	DVB-T2



Бусад 10 000 хүртэлх хүн амтай сүм, суурин	470-566 МГц	DVB-T2	566-702 МГц	DVB-T DVB-T2
--	-------------	--------	-------------	--------------

2.4 Үндэсний болон орон нутгийн ТӨН-т ашиглах IV царааны давтамжийн хуваарилалтад зэргэлдээ /n±1/ сувгийг ашиглахгүй.

2.5 Олон сувгийг олон цэгт түгээх системд ашиглах давтамжийн зурвасын хуваарилалтад зэргэлдээ /n±1/ сувгийг ашиглана.


2.6 Хуваарилагдсан сувагт дамжуулах техникийн мэдээлэл дамжуулах урсгалын хэмжээг тохируулахдаа MNS 6400:2013 стандартын үзүүлэлтүүдийг баримтлан хүснэгт 5-т үзүүлсэн нэгж програмд ноогдох мэдээллийн багтаамж, шахалтын технологийг хангасан байхаар хийнэ.

Хүснэгт 5. Нэгж програм ноогдох урсгалын хурд, шахалтын технологи

DVB-T /MPEG-2/		DVB-T2 MPEG4 /H.264/AVC/	
SDTV	HDTV	SDTV	HDTV
3 Мбит/с	16 Мбит/с	1.5 Мбит/с	8 Мбит/с

2.7 Тоон телевизийн өргөн нэвтрүүлгийн нэвтрүүлэгчийн чадал 500 Вт-аас дээш бол тухайн сувгийн өргөнд тохируулсан зурвасын шүүрийг ашиглана.

-----oOo-----



“Телевизийн өргөн нэвтрүүлгийн станцад ашиглах
радио давтамжийн зурvasын хуваарилалт, техникийн
нөхцөл, шаардлага”-ын
Хоёрдугаар хавсралт

**Улаанбаатар хотын бусэд Үндэсний телевизийн сүлжээгээр дамжуулах станцуудад ашиглах
радио давтамжийн 470-534 МГц-ийн зурvasын хуваарилалт**

1. Улаанбаатар хот болон хотын хаалттай, алслагдсан дүүрэгт ашиглах тоон телевизийн өргөн нэвтрүүлгийн радио давтамжийн сувгийн хуваарилалтыг Хүснэгт 1-т үзүүлэв.
2. Улаанбаатар хотод тоон телевизийн сүлжээг нэг давтамжийн сүлжээгээр зохион байгуулах ба 2-оос доошгүй цэгээс дамжуулалтыг хийнэ.

**Хүснэгт 1. Улаанбаатар хотод ашиглах тоон телевизийн өргөн нэвтрүүлгийн төрийн сүлжээний
сувгийн хуваарилалт**

Тоон телевизийн давтамж, сувгийн төлөвлөлт		Байршил	
Зурvasын өргөн	Сувгийн дугаар	№	Нэр
478-486 МГц	22	1	Телевизийн төв
		2	Баянхошуу
		3	Чингэлтэй уул
470-478 МГц	21	4	Партизан
486-494 МГц	23	5	Булагтай баг
		6	Городок
494-502 МГц	24	7	Багахангай
510-518 МГц	26	8	Тэрэлж
518-526 МГц	27	9	Баганур
526-534 МГц	28	10	Жанчивлан
		11	Налайх төв
542-550 МГц	30	12	Өлзийт
		13	ТЗ,61-н гарам
494-502 МГц	24	14	Бэлх
		15	Гачуурт
		16	Био комбинат
		17	Хүрэлтогоот
		18	Нисэх

3. Улаанбаатар хотын үндсэн болон дахин дамжуулах станцуудад ашиглах тоон телевизийн өргөн нэвтрүүлгийн станцуудыг тохируулах MNS 6400:2013 стандартын үзүүлэлтүүдийг баримтлана.

-----00-----



“Телевизийн өргөн нэвтрүүлгийн станцад ашиглах
радио давтамжийн зурvasын хуваарилалт, техникийн
нөхцөл, шаардлага”-ын
Гуравдугаар хавсралт

**УЛСЫН ХЭМЖЭЭНД УЛААНБАТАР ХОТЫН БҮСЭЭС БУСАД БАЙРШИЛД
ТЕЛЕВИЗИЙН ДАМЖУУЛАХ СТАНЦУУДАД АШИГЛАХ РАДИО ДАВТАМЖИЙН
470-566 МГЦ-ИЙН ЗУРВАСЫН ХУВААРИЛАЛТ**

1. Архангай аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
1	1	Цэцэрлэг хот	21, 23, 25, 27
2	2	Батцэнгэл	22, 24, 26, 28
3	3	Булган	22, 24, 26, 28
4	4	Жаргалант	22, 24, 26, 28
5	5	Ихтамир	22, 24, 26, 28
6	6	Өндөр-Улаан	22, 24, 26, 28
7	7	Өлзийт	22, 24, 26, 28
8	8	Өгийнуур	23, 25, 27, 29
9	9	Тариат	21, 23, 25, 27
10	10	Түвширүүлэх	24, 26, 28, 30
11	11	Хангай	24, 26, 28, 30
12	12	Хайрхан	24, 26, 28, 30
13	13	Хашаат	21, 23, 25, 27
14	14	Хотонт	22, 24, 26, 28
15	15	Цэнхэр	23, 25, 27, 29
16	16	Чулуут	22, 24, 26, 28
17	17	Эрдэнэмандал	23, 25, 27, 29
18	18	Цахир	22, 24, 26, 28
19	19	Цэцэрлэг	21, 23, 25, 27
20	20	Малчны хороолол	21, 23, 25, 27

2. Баянхонгор аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
21	1	Баянхонгор	22, 24, 26, 28
22	2	Баянбулаг	21, 23, 25, 27
23	3	Баянговь	21, 23, 25, 27
24	4	Баянлиг	23, 25, 27, 29
25	5	Баян-Овоо	21, 23, 25, 27
26	6	Баян-Өндөр	21, 23, 25, 27
27	7	Баацагаан	23, 25, 27, 29
28	8	Баянцагаан	22, 24, 26, 28
29	9	Богд	23, 25, 27, 29



2. Баянхонгор аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
30	10	Бөмбөгөр	23, 25, 27, 29
31	11	Бууцагаан	22, 24, 26, 28
32	12	Галуут	21, 23, 25, 27
33	13	Гурванбулаг	22, 24, 26, 28
34	14	Жаргалант	23, 25, 27, 29
35	15	Жинст	24, 26, 28, 30
36	16	Өлзийт	24, 26, 28, 30
37	17	Шинэжинст	22, 24, 26, 28
38	18	Эрдэнэцогт	23, 25, 27, 29
39	19	Заг	21, 23, 25, 27
40	20	Хүрээмарал	24, 26, 28, 30
41	21	Шаргалжуут	24, 26, 28, 30

3. Баян-Өлгий аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
42	1	Өлгий хот	21, 23, 25, 27
43	2	Алтай	22, 24, 26, 28
44	3	Алтанцөгц	22, 24, 26, 28
45	4	Баяннуур	23, 25, 27, 29
46	5	Буянт	23, 25, 27, 29
47	6	Дэлүүн	23, 25, 27, 29
48	7	Ногооннуур	24, 26, 28, 30
49	8	Булган	21, 23, 25, 27
50	9	Толбо	22, 24, 26, 28
51	10	Улаанхус	23, 25, 27, 29
52	11	Цэнгэл	24, 26, 28, 30
53	12	Цагааннуур	23, 25, 27, 29
54	13	Согобаг/Улаанхус/	23, 25, 27, 29
55	14	Сагсай	22, 24, 26, 28
56	15	Хотгор баг	24, 26, 28, 30
57	16	Улаанбайшинг	22, 24, 26, 28

4. Булган аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
58	1	Булган хот	23, 25, 27, 29
59	2	Баян-Агт	21, 23, 25, 27
60	3	Бугат	22, 24, 26, 28
61	4	Бүрэгхангай	24, 26, 28, 30
62	5	Могод	21, 23, 25, 27
63	6	Орхон	23, 26, 28, 30




4. Булган аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
64	7	Сайхан	24, 26, 28, 30
65	8	Сэлэнгэ	24, 26, 28, 30
66	9	Тэшиг	21, 23, 25, 27
67	10	Хангал	23, 25, 27, 29
68	11	ХишигӨндөр	22, 24, 26, 28
69	12	ХутагӨндөр	22, 24, 26, 28
70	13	Үнвт	23, 25, 27, 29
71	14	Хонгор	22, 24, 26, 28
72	15	Уурхай	24, 26, 28, 30
73	16	Атар	24, 26, 28, 30
74	17	Хялганат	22, 24, 26, 28
75	18	Гурванбулаг	22, 24, 26, 28
76	19	Дашинчилэн	21, 23, 25, 27
77	20	Рашаант/Сансар	24, 26, 28, 30
78	21	Баяннуур	24, 26, 28, 30

5. Говь-Алтай аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
79	1	Алтай хот	21, 23, 25, 27
80	2	Баян-Уул	21, 23, 25, 27
81	3	Бигэр	22, 24, 26, 28
82	4	Бугат	21, 23, 25, 27
83	5	Дарви	21, 23, 25, 27
84	6	Дэлгэр	23, 25, 27, 29
85	7	Жаргалан	22, 24, 26, 28
86	8	Тайшир	23, 25, 27, 29
87	9	Тонхил	22, 24, 26, 28
88	10	Төгрөг	22, 24, 26, 28
89	11	Халиун	23, 25, 27, 29
90	12	Хөхморьт	22, 24, 26, 28
91	13	Цогт	22, 24, 26, 28
92	14	Цээл	22, 24, 26, 28
93	15	Чандмань	24, 26, 28, 30
94	16	Шарга	24, 26, 28, 30
95	17	Эрдэнэ	23, 25, 27, 29
96	18	Гуулин	23, 25, 27, 29
97	19	Алтай	21, 23, 25, 27
98	20	Баянтоорой	21, 23, 25, 27



6. Говь-Сүмбэр аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
99	1	Чойр хот	24, 26, 28, 30
100	2	Баянтал	21, 23, 25, 27
101	3	Шивээ говь	21, 23, 25, 27

7. Дархан-Уул аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
102	1	Дархан	23, 25, 27, 39
103	2	Хонгор	23, 25, 27, 29
104	3	Орхон/жимс ногоо	24, 26, 28, 30
105	4	Шарын гол	23, 25, 27, 29

8. Дорноговь аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
106	1	Сайншанд	21, 23, 25, 27
107	2	Алтанширээ	22, 24, 26, 28,
108	3	Мандах	22, 24, 26, 28
109	4	Өргөн	22, 24, 26, 28
110	5	Сайхандулаан	21, 23, 25, 27
111	6	Улаанбадрах	22, 24, 26, 28
112	7	Хатанбулаг	21, 23, 25, 27
113	8	Хөвсгөл	21, 23, 25, 27
114	9	Эрдэнэ	22, 24, 26, 28
115	10	Замын-Үүд	24, 26, 28, 30
116	11	Зүүнбаян	24, 26, 28, 30
117	12	Айраг	22, 24, 26, 28
118	13	Даланжаргалан	23, 25, 27, 29
119	14	Дэлгэрэх	23, 25, 27, 29
120	15	Иххэт/Зүлэгт/	24, 26, 28, 30

9. Дорнод аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
121	1	Чойбалсан хот	25, 27, 29, 31
122	2	Баяндун	21, 23, 25, 27
123	3	Баян-Уул	21, 23, 25, 27
124	4	Булган	22, 24, 26, 28
125	5	Гурванзагал	22, 24, 26, 28
126	6	Дашбалбар	21, 23, 25, 27
127	7	Матад	21, 23, 25, 27
128	8	Сэргэлэн	24, 26, 28, 30

9. Дорнод аймаг


№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
129	9	Халхгол	21, 23, 25, 27
130	10	Хөлөнбуйр	22, 24, 26, 28
131	11	Цагаан овоо	22, 24, 26, 28
132	12	Чулуунхороот	22, 24, 26, 28
133	13	Эрээн баг	22, 24, 26, 28
134	14	Чойбалсан	24, 26, 28, 30

10. Дундговь аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
135	1	Мандалговь хот	22, 24, 26, 28
136	2	Баянжаргалан	21, 23, 25, 27
137	3	Говь-Угтаал	23, 25, 27, 29
138	4	Гурвансайхан	23, 25, 27, 29
139	5	Дэлгэрхангай	22, 24, 26, 30
140	6	Дэлгэрцогт	23, 25, 27, 29
141	7	Дэрэн	21, 23, 25, 27
142	8	Луус	21, 23, 25, 27
143	9	Өлзийт	21, 23, 25, 27
144	10	Өндөршил	24, 26, 28, 30
145	11	Сайхан овоо	21, 23, 25, 27
146	12	Хулд	23, 25, 27, 29
147	13	Цагаандэлгэр	25, 27, 29, 31
148	14	Эрдэнэдалай	23, 25, 27, 29
149	15	Адаацаг	21, 23, 25, 27

11. Завхан аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
150	1	Улиастай	22, 24, 26, 28
151	2	Алдархаан	24, 26, 28, 30
152	3	Баянтэс	23, 25, 27, 29
153	4	Баянхайрхан	23, 25, 27, 29
154	5	Дөрвөлжин	23, 25, 27, 29
155	6	Завханмандал	21, 23, 25, 27
156	7	Идэр	22, 24, 26, 28
157	8	Их-Уул	21, 23, 25, 27
158	9	Номрөг	21, 23, 25, 27
159	10	Огтон	23, 25, 27, 29
160	11	Сантмаргац	23, 25, 27, 29
161	12	Сонгино	24, 26, 28, 30



11. Завхан аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
162	13	Түдэвтэй	22, 24, 26, 28
163	14	Тэлмэн	22, 24, 26, 28
164	15	Тэс	21, 23, 25, 27
165	16	Ургамал	22, 24, 26, 28
166	17	Цагаанхайрхан	23, 25, 27, 29
167	18	Цагаанчулут	24, 26, 28, 30
168	19	Цэцэн-уул	22, 24, 26, 28
169	20	Шилүүстэй	22, 24, 26, 28
170	21	Эрдэнхайрхан	24, 26, 28, 30
171	22	Яруу	22, 24, 26, 28
172	23	Асгат	24, 26, 28, 30
173	24	Тосонцэнгэл	24, 26, 28, 30

12. Орхон аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
174	1	Баян-Өндөр	23, 26, 28, 34
175	2	ПДҮ	21, 23, 25, 27
176	3	Говил	21, 23, 25, 27
177	4	Жаргалант	24, 26, 28, 30

13. Өвөрхангай аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
178	1	Арвайхээр	23, 25, 27, 29
179	2	Баруунбаян Улаан	22, 24, 26, 28
180	3	Бат-Өлзий	22, 24, 26, 28
181	4	Баянгол	22, 24, 26, 28
182	5	Баян-өндөр	24, 26, 28, 30
183	6	Богд	22, 24, 26, 28
184	7	Бүрд	22, 24, 26, 28
185	8	Гучин Ус	22, 24, 26, 28
186	9	Зүйл	21, 23, 25, 27
187	10	Зүүнбаян Улаан	21, 23, 25, 27
188	11	Нарийнтээл	21, 23, 25, 27
189	12	Өлзийт	24, 26, 28, 30
190	13	Тарагт	22, 24, 26, 28
191	14	Төгрөг	21, 23, 25, 27
192	15	Сант	22, 24, 26, 28
193	16	Уянга	24, 26, 28, 30
194	17	Хайрхандулаан	21, 23, 25, 27



13. Өвөрхангай аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
195	18	Хархорин	23, 25, 27, 29
196	19	Хужирт	24, 26, 28, 30
197	20	Баянтээг	23, 25, 27, 29

14. Өмнөговь аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
198	1	Даланзадгад	25, 27, 29, 31
199	2	Баяндалай	24, 26, 28, 30
200	3	Баяновоо	21, 23, 25, 28
201	4	Булган	22, 24, 26, 29
202	5	Гурвантэс	21, 23, 25, 29
203	6	Мандал-овоо	23, 25, 27, 29
204	7	Манлай	23, 25, 27, 29
205	8	Номгон	22, 24, 26, 28
206	9	Ноён	23, 25, 27, 29
207	10	Сэврэй	24, 26, 28, 30
208	11	Ханбогд	21, 23, 25, 27
209	12	Ханхонгор	23, 25, 27, 29
210	13	Хүрмэн	22, 24, 26, 28
211	14	Цогтвоо	24, 26, 28, 30
212	15	Цогцэций	24, 26, 28, 30

15. Сүхбаатар аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
213	1	Баруун урт	23, 27, 29, 31
214	2	Асгат	21, 23, 25, 27
215	3	Баяндэлгэр	21, 23, 25, 27
216	4	Дарьганга	21, 23, 25, 27
217	5	Мөнххаан	23, 25, 27, 29
218	6	Наран	22, 24, 26, 28
219	7	Онгон	22, 24, 26, 28
220	8	Сүхбаатар	22, 24, 26, 28
221	9	Түвшинширээ	22, 24, 26, 28
		Түмэнцогт	23, 25, 27, 29
222	10	Уулбаян	21, 23, 25, 27
223	11	Халзан	23, 25, 27, 29
224	12	Эрдэнэцагаан	22, 24, 26, 28



16. Сэлэнгэ аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
225	1	Сүхбаатар	22, 24, 26, 28
226	2	Мандал/Зүүнхараа	21, 23, 25, 27
227	3	Алтанбулаг	21, 23, 25, 27
228	4	Баянгол/Баруунхар	23, 25, 27, 29
229	5	Баруунбүрэн	22, 24, 26, 28
230	6	Ерөө	21, 23, 25, 27
231	7	Зүүнбүрэн	23, 25, 27, 29
232	8	Орхон	23, 25, 27, 29
233	9	Орхонтуул	23, 25, 27, 29
234	10	Сайхан /Хөтөл	22, 24, 26, 28
235	11	Сант/Цагаантолгой	21, 23, 25, 27
236	12	Түшиг/Зэлтэр	21, 23, 25, 27
237	13	Хүдэр	22, 24, 26, 28
238	14	Жавхлант/Баянхар	23, 25, 27, 29
239	15	Цагаанинур	24, 26, 28, 30
240	16	Хушаат/Энхтал	21, 23, 25, 27
241	17	Бугант	23, 25, 27, 29
242	18	Дулаанхаан	21, 23, 25, 27
243	19	Түнхэл	24, 26, 28, 30
244	20	Сайхан/Номгон баг	23, 25, 27, 29
245	21	Бүрэнтолгой	21, 23, 25, 27
246	22	Орхонтуул/Шар ус	23, 25, 27, 29
247	23	Салхит	24, 26, 28, 30
248	24	Шаамар	24, 26, 28, 30

17. Төв аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
249	1	Зуунмод	21, 23, 25, 27
250	2	Батсүмбэр	22, 24, 26, 28
251	3	Баян	22, 24, 26, 28
252	4	Баяндэлгэр	21, 23, 25, 27
253	5	Баянжаргалан	22, 24, 26, 28
254	6	Баян-өнжүүл	22, 24, 26, 28
255	7	Баянцагаан	23, 25, 27, 29
256	8	Баянцогт	24, 26, 28, 30
257	9	Борнуур	23, 25, 27, 29
258	10	Бүрэн	24, 26, 28, 30
259	11	Дэлгэрхаан	22, 24, 26, 28
260	12	Жаргалант	21, 23, 25, 27
261	13	Заамар	23, 25, 27, 29




17. Төв аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
262	14	Лүн	24, 26, 28, 30
263	15	Мөнгөнморьт	21, 23, 25, 27
264	16	Өндерширээт	22, 24, 26, 28
265	17	Сэргэлэн	23, 25, 27, 29
266	18	Угтаал	21, 23, 25, 27
267	19	Эрдэнэсант	21, 23, 25, 27
268	20	Баянчандмань	23, 26, 28, 30
269	21	Цээл	24, 26, 28, 30
270	22	Баянхангай	21, 23, 25, 27
271	23	Аргалант	23, 25, 27, 29
272	24	Архуст	24, 26, 28, 30
273	25	Алтанбулаг	21, 23, 25, 27
274	26	Сүмбэр	22, 24, 26, 28
275	27	Эрдэнэ	22, 24, 26, 28

18. Увс аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
276	1	Улаангом	22, 24, 26, 28
277	2	Баруунтуруун	23, 25 , 27, 29
278	3	Бөхмерөн	22, 24, 26, 28
279	4	Давст	22, 24, 26, 28
280	5	Завхан	22, 24, 26, 28
281	6	Зүүнговь	22, 24, 26, 28
282	7	Зүүнхангай	22, 24, 26, 28
283	8	Малчин	23, 25 , 27, 29
284	9	Наранбулаг	24, 26, 28, 30
285	10	Өлгий	23, 25 , 27, 29
286	11	Өмнөговь	21, 23, 25, 27
287	12	Өндөрхангай	21, 23, 25, 27
288	13	Сагил	24, 26, 28, 30
289	14	Тариалан	23, 25, 27, 29
290	15	Түргэн	21, 23, 25, 27
291	16	Тэс	21, 23, 25, 27
292	17	Ховд	24, 26, 28, 30
293	18	Хяргас	21, 23, 25, 27
294	19	Цагаанхайрхан	22, 24, 26, 28



19. Ховд аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
295	1	Ховд хот	22, 24, 26, 28
296	2	Алтай	22, 24, 26, 28
297	3	Булган	23, 25, 27, 29
298	4	Буянт	22, 24, 26, 28
299	5	Дарви	22, 24, 26, 28
300	6	Дуут	23, 25, 27, 29
301	7	Зэрэг	23, 25, 27, 29
302	8	Манхан	21, 23, 25, 27
303	9	Мянгад	23, 25, 27, 29
304	10	Мөст	24, 26, 28, 30
305	11	Мөнххайрхан	22, 24, 26, 28
306	12	Үенч	21, 23, 25, 27
307	13	Ховд	23, 25, 27, 29
308	14	Цэцэг	21, 23, 25, 27
309	15	Чандмань	21, 23, 25, 27
310	16	Эрдэнэбүрэн	21, 23, 25, 27
311	17	Дөргөн	22, 24, 26, 28

20. Хөвсгөл аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
312	1	Мөрөн	23, 29, 31, 33
313	2	Алаг-Эрдэнэ	22, 24, 26, 28
314	3	Арбулаг	23, 25, 27, 29
315	4	Баянзүрх	24, 26, 28, 30
316	5	Бүрэнтогтох	24, 26, 28, 30
317	6	Галт	22, 24, 26, 28
318	7	Жаргалант	23, 25, 27, 29
319	8	Их-Уул	24, 26, 28, 30
320	9	Рашаант	23, 25, 27, 29
321	10	Рэнчинлхүмбэ	22, 24, 26, 28
322	11	Тариалан	22, 24, 26, 28
323	12	Тосонцэнгэл	22, 24, 26, 28
324	13	Төмөрбулаг	23, 25, 27, 29
325	14	Түнэл	24, 26, 28, 30
326	15	Улаан-Уул	21, 23, 25, 27
327	16	Ханх	21, 23, 25, 27
328	17	Цагаан-Уул	22, 24, 26, 28
329	18	Цагаан-Үүр	21, 23, 25, 27
330	19	Цэцэрлэг	22, 24, 26, 28
331	20	Чандмань-Өндөр	22, 24, 26, 28


20. Хөвсгөл аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
332	21	Шинэ-Идэр	24, 26, 28, 30
333	22	Хатгал	23, 25, 27, 29
334	23	Цагааннуур	21, 23, 25, 27
335	24	Эрдэнбулган	23, 25, 27, 29

21. Хэнтий аймаг

№		Сум, суурингийн нэр	Телевизийн сувгийн төлөвлөлт
336	1	Өндөрхаан хот	21, 25, 27, 29
337	2	Батноров	22, 24, 26, 28
338	3	Батширээт	21, 23, 25, 27
339	4	Баян-Адарга	21, 23, 25, 27
340	5	Баянмөнх	23, 25, 27, 29
341	6	Баян-овоо	21, 23, 25, 27
342	7	Баянхутаг	22, 24, 26, 28
343	8	Биндэр	22, 24, 26, 28
344	9	Галшир	23, 25, 27, 29
345	10	Дадал	21, 23, 25, 27
346	11	Дархан	21, 23, 25, 27
347	12	Дэлгэрхаан	22, 24, 26, 28
348	13	Жаргалтхаан	24, 26, 28, 30
349	14	Норовлин	22, 24, 26, 28
350	15	Өмнөдэлгэр	22, 24, 26, 28
351	16	Хэрлэн Баян-улаан	21, 23, 25, 27
352	17	Цэнхэрмандал	22, 24, 26, 28
353	18	Бэрх	23, 25, 27, 29
354	19	Өлзийт	24, 26, 28, 30
355	20	Бор-Өндөр	23, 25, 27, 29
356	21	Хурх	23, 25, 27, 29
357	22	Мөрөн	21, 23, 25, 27

-----00-----



“Телевизийн өргөн нэвтрүүлгийн станцад ашиглах
радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн
нөхцөл, шаардлага”-ын
Дөрөвдүгээр хавсралт

ТӨН-Т АШИГЛАХ РАДИО РЕЛЕЙНИЙ СТАНЦЫН РАДИО ДАВТАМЖИЙН ЗУРВАСЫН ХУВААРИЛАЛТ, ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

Нэг. Техникийн нөхцөл шаардлага

1. Радио давтамжийн 1164-1215, 1240-1300, 1350-1400, 2025-2100 МГц-ийн зурваст ажиллах тоон радио релейний станцын зурвасын хуваарилалт, ашиглалтын шаардлага тусгагдсан. Үүнд:

- 1.1 Энэхүү радио давтамжийн зурвасууд нь тоон модуляци ашигласан бага багтаамжийн радио релейний системийн төрөлд орно.
- 1.2 Тоон радио системүүд нь шууд нэг чиглэлд суурин, зөөврийн болои хөдөлгөөнт холбооны сүлжээ үүсгэх ба зурвасын өргөн 8 МГц-ээс хэтрэхгүй байна.
- 1.3 Радио релейний систем нь яриа, өгөгдөл, дүрс ба телевизийн дохио дамжуулахад зориулагдана.

Хоёр. Радио давтамжийн сувгийн хуваарилалт

2.1 Үндэсний радио давтамжийн зурвасын хуваарилалт, ашиглалтыг хүснэгт 1-д үзүүлэв.


Хүснэгт 1. 1164-1215, 1240-1300, 1350-1400, 2025-2100 МГц-ийн радио давтамжийн зурвасын хуваарилалт, ашиглалт

ОУЦХБ-ын хуваарилалт I бүс	Үндэсний хуваарилалт	Ашиглалт
1164-1 215 АГААРЫН РАДИОНАВИГАЦИ РАДИОНАВИГАЦИ- ХИЙМЭЛ ДАГУУЛ (сансар- газар) (сансар-сансар)	1 164-1 215 АГААРЫН РАДИОНАВИГАЦИ РАДИОНАВИГАЦИ- ХИЙМЭЛ ДАГУУЛ (сансар-газар) (газар - сансар)	1164-1215 МГц зурвасыг телевизийн үйлчилгээний утасгүй холболтын цэгээс цэгт дамжуулах тоон системд ашиглана.
1 215-1 240 ДЭЛХИЙ СУДЛАХ ХИЙМЭЛ ДАГУУЛ (идэвхитэй) РАДИОЛОКАЦИ РАДИОНАВИГАЦИ- ХИЙМЭЛ ДАГУУЛ (сансар- газар) (сансар-сансар) САНСАР СУДЛАЛ (идэвхитэй)	1 215-1 240 ДЭЛХИЙ СУДЛАХ ХИЙМЭЛ ДАГУУЛ (идэвхитэй) РАДИОЛОКАЦИ РАДИОНАВИГАЦИ- ХИЙМЭЛ ДАГУУЛ (сансар-газар) САНСАР СУДЛАЛ (идэвхитэй)	1215-1350 МГц-ийн давтамжийн зурвасыг агаарын хайлт хийх радарын тоног төхөөрөмжинд ашиглана. 1227.6 МГц-ийн давтамжинд сансраас дэлхий дээрх тухайн байршил тодорхойлогч



1 240-1 300 ДЭЛХИЙ СУДЛАХ ХИЙМЭЛ ДАГУУЛ (идэвхитэй) РАДИО НАВИГАЦИ- ХИЙМЭЛ ДАГУУЛ (сансар- газар)(сансар-сансар) САНСАР СУДЛАЛ (идэвхитэй) Сонирхогч	1 240-1 300 ДЭЛХИЙ СУДЛАХ ХИЙМЭЛ ДАГУУЛ (идэвхитэй) РАДИОЛОКАЦИ РАДИОНАВИГАЦИ- ХИЙМЭЛ ДАГУУЛ (сансар-газар) САНСАР СУДЛАЛ (идэвхитэй)	(GPS) тохеөрөмж ажиллана. 1240-1300 МГц зурvasыг телевизийн үйлчилгээний утасгүй холболтын цэгээс цэгт дамжуулах тоон системд ашиглана
1 300-1 350 РАДИОЛОКАЦИ АГААРЫН РАДИОНАВИГАЦИ Радионавигаци –хиймэл дагуул (газар -сансар)	1 300-1 350 РАДИОЛОКАЦИ АГААРЫН РАДИОНАВИГАЦИ Радионавигаци (газар- сансар)	1350-1400 МГц-ийн давтамжийн зурvasыг телевизийн үйлчилгээний утасгүй холболтын цэгээс цэгт дамжуулах тоон системд ашиглана. 1350-1517 МГц зурvasыг хөдөлгөөнт радио релейнд ашиглана.
1 350-1 400 ХӨДӨЛГӨӨНТ БУС ХӨДӨЛГӨӨНТ РАДИОЛОКАЦИ	1 350-1 400 ХӨДӨЛГӨӨНТ БУС ХӨДӨЛГӨӨНТ РАДИОЛОКАЦИ	хөдөлгөөнт радио релейнд ашиглана.
2 025-2 110 САНСАР АШИГЛАЛТ (газар-сансар) (сансар- сансар) ДЭЛХИЙ СУДЛАХ- ХИЙМЭЛ ДАГУУЛ (газар- сансар) (сансар-сансар) ХӨДӨЛГӨӨНТ БУС ХӨДӨЛГӨӨНТ САНСАР СУДЛАЛ (газар- сансар) (сансар-сансар)	2 025-2 110 САНСАР АШИГЛАЛТ (газар-сансар) (сансар- сансар) ДЭЛХИЙ СУДЛАХ- ХИЙМЭЛ ДАГУУЛ (газар- сансар) (сансар-сансар) ХӨДӨЛГӨӨНТ БУС ХӨДӨЛГӨӨНТ САНСАР СУДЛАЛ (газар- сансар) (сансар-сансар)	2025-2100 МГц-ийн давтамжийн зурvasыг телевизийн үйлчилгээний утасгүй холболтын цэгээс цэгт дамжуулах тоон системд ашиглана.

2.2 Бага багтаамжийн 8 МГц-ийн зурvasын өргөнтэй радио суваг үүсгэх ба сувгийн хуваарилалтыг хүснэгт 2-т үзүүлэв.



Хүснэгт 2. 1164-1215, 1240-1300, 1350-1400, 2025-2100 МГц-ийн радио давтамжийн зурвасын хуваарилалт, ашиглалт

Сувгийн дугаар	Төвийн давтамж (МГц)	Зурвасын өргөн (МГц)	Сувгийн дугаар	Төвийн давтамж (МГц)	Зурвасын өргөн (МГц)
A1	1164.0	1160.0-1168.0	A4	1188.0	1184.0-1192.0
A2	1172.0	1168.0-1176.0	A5	1196.0	1192.0-1200.0
A3	1180.0	1176.0-1184.0	A6	1204.0	1200.0-1208.0
B1	1248.0	1244.0-1252.0	B5	1280.0	1276.0-1284.0
B2	1256.0	1252.0-1260.0	B6	1288.0	1284.0-1292.0
B3	1264.0	1260.0-1268.0	B7	1296.0	1292.0-1300.0
B4	1272.0	1268.0-1276.0			
C1	1354.0	1350.0-1358.0	C4	1378.0	1374.0-1382.0
C2	1362.0	1358.0-1366.0	C5	1386.0	1382.0-1390.0
C3	1370.0	1366.0-1374.0	C6	1394.0	1390.0-1398.0
D1	2031.0	2027.0-2035.0	D6	2071.0	2067.0-2075.0
D2	2039.0	2035.0-2043.0	D7	2079.0	2075.0-2083.0
D3	2047.0	2043.0-2051.0	D8	2087.0	2083.0-2091.0
D4	2055.0	2051.0-2059.0	D9	2095.0	2091.0-2099.0
D5	2063.0	2059.0-2067.0			

Гурав. Радио давтамжийн сувгийг хуваарилах техникийн нөхцөл, шаардлага

3.1 ТӨН-т ашиглах радио релейний станц нь ашиглах зориулалтаас хамаарч доорхи төрлийн иж бүрдэлтэй байна. Үүнд:

3.1.1 Утасгүй камерын станц нь зөөврийн болон хөдөлгөөнт үед ашиглах зориулалт бүхий өргөн нэвтрүүлгийн чанартай дуу дүрсийг богино зайд дамжуулах цацах нэвтрүүлэгч, антенн, тэжээл болон камераас бүрдэнэ.

3.1.2 Зөөврийн дүрсийн станц нь биедээ болон зөөврийн байдлаар авч явах боломжтой нэвтрүүлэгч, антенн, тэжээлийн төхөөрөмжийн бүрдэл.

3.1.3 Хөдөлгөөнт дүрсийн станц нь машин, нисэх онгоц болон бусад хөдөлгөөнт нөхцөлд ашиглах боломжтой суурилагдсан холболтын төхөөрөмжийн бүрдэл.

3.1.4 Түр зуур богино хугацаанд цэгээс цэгийн хооронд мэдээ дамжуулах зориулалт бүхий бага багтаамжийн радио релейний шугамын төхөөрөмжийн бүрдэл.

3.2 Хэрэглэгч нь нэг байршилд байгаа бусад радио төхөөрөмжүүдэд радио давтамжийн суваг, чадлын хувьд нөлөөлөхгүйгээр ашиглана.

3.3 Антенны байгууламж нь аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан, зориулалтын цамхагт байрласан ба газардуулга хийж орчиндоо аюулгүй байхаар бэхлэгдсэн байна.

3.4 Явуулын болон утасгүй камерын станцыг ашиглахдаа антенн, өсгөгчийн байгууламж нь аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангаж орчиндоо аюулгүй байхаар ашиглана.

-----оо-----

